



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/530.

Есөнбулаг

Газрыг нөхөн олговортойгоор солих
буюу эргүүлэн авах, газрын байршил
өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10.2, 29.10.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Есөнбулаг сумын Харзат багийн "Гэр хорооллын дахин төлөвлөлт хийх замаар инженерийн нэгдсэн шугам сүлжээний холболт" ажлын хүрээнд нөлөөлөлд өртсөн иргэн Гаанжуурын Ганбаатар (ДЭ65052410)-ын эзэмшлийн 8208001995 нэгж талбарын дугаартай, иргэн Пүрэвхүүгийн Цэндсүрэн (ЦГ68032702)-ийн өмчлөлийн 8208000171 нэгж талбарын дугаартай газрыг нөхөн олговортойгоор эргүүлэн авах газрын байршлыг 1-2 дугаар хавсралтаар, Г.Ганбаатар, П.Цэндсүрэн нарын нөхөн олговортойгоор биеийн тамир, спортын төв (2107)-ийн зориулалтаар эзэмших эрхээр олгох 1123 м2 газрын байршлыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Холбогдох хуулийн дагуу гэр бүлийн хэрэгцээнд газар өмчилсөн иргэнд талбайн хэмжээг өөрчилж, кадастрын зураг үйлдэж, тэмдэгжүүлж, баталгаажуулах, эзэмшсэн газрын мэдээллийг Газрын удирдлагын нэгдсэн системд холбогдох журмын дагуу бүртгэн баталгаажуулж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Гаадамба)-т, өмчлөх эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулж, гэрчилгээжүүлэхийг Улсын бүртгэлийн хэлтэс (Г.Чүлтэмжамц)-т тус тус даалгасугай.

3.Эрхээ холбогдох хууль тогтоомжийн дагуу баталгаажуулж, эзэмшсэн газартаа газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг хугацаанд нь хийлгэж байхыг дээрх иргэдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

**ИРГЭН Пүрэвхүү ОВОГТОЙ Цэндсүрэн (ЦГ68032702) - ИЙН
ӨМЧИЛЖ БАЙГАА ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ**


Нэгж талбарын дугаар: 820800...

Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, харзат баг 12-17 тоот

20⁰⁴ оны ... дугаар сарын ...-ны өдрийн
Аймгийн Засаг даргын
М.С.О. дугаар захирамжийн ...-р хавсралт



Огноо: 2023-12-20



Хашлагы координат:

Дугаар	X	Y	Урт	Цэгүүд
1	5138744.901	288319.816	46.73	1-2
2	5138783.401	288293.331	5.50	2-3
3	5138780.283	288288.800	8.08	3-4
4	5138786.940	288284.221	11.55	4-5
5	5138794.700	288292.780	50.06	5-6
6	5138752.810	288320.180	6.06	6-7
7	5138747.870	288323.370	4.50	7-1


Талбайн хэмжээ: 341.3 квадрат метр

Зургийн масштаб 1:1 000 (1 сантиметр 10 метр багтана)

**ИРГЭН ПҮРЭВХҮҮ ОВОГТОЙ ЦЭНДСҮРЭН (ЦГ68032702) - ИЙН
ЭЗЭМШИХ ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ**

Нэгж талбарын дугаар: 620800...

Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Оргил баг



Хашлаганы координат:

Дугаар	X	Y	Урт	Цэгүүд
1	5139032.426	289532.619	31.20	1-2
2	5139057.042	289513.649	36.00	2-3
3	5139079.161	289542.063	31.20	3-4
4	5139064.545	289561.223	36.00	4-1

Талбайн хэмжээ: 1123.2 квадрат метр

Зургийн масштаб 1:1 000 (1 сантиметрт 10 метр багтана)